



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/69/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 260512 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Уваа уул аудит ХХК-ийн
Захирал Ч.Мөнхтуяа
Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажилагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа.....	15
8.2 Төлбөрийн акт.....	15
8.3 Албан шаардлага.....	15
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээвэр хөгжлийн яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ҮЦК	Үнэт цаасны компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/611
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭС АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БОЛОРМАА ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллага нь зорилтот түвшний нийт орлогыг 531.3 сая төгрөгөөр, зардлыг 1,195.8 сая төгрөгөөр 564.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна. Алдагдлыг Эрдэнэс монгол ХХК-аас авах 564.5 сая төгрөгийн зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр орлого бүрдүүлээгүй, 560.5 сая төгрөгийн зээлийн санхүүжилт авч, 601.9 сая төгрөгийн зардал гарган, 601.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагаа эхлээгүйгээс орлогын төлөвлөгөө тасарсан, нийт зардлын гүйцэтгэл 601.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 594.1 сая төгрөг буюу 49.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авахад зээлийн эх үүсвэрээс 21.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд 6 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	22,929,643.03	41,355,741.09
1.1.2	Дансны авлага		1,972,400.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	25,115.30	78,000.00
1.1.4	Бусад авлага	244,000.00	
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	150,000.00	500,187.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	23,348,758.33	43,906,328.09
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,572,197.97	26,086,284.38
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,572,197.97	26,086,284.38
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>33,920,956.30</u>	<u>69,992,612.47</u>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		5,419,800.00
2.1.1.2	Цалингийн өглөг		5,274.00
2.1.1.3	Татварын өр	285,555.00	
2.1.1.5	Богино хугацаат зээл	276,527,625.00	560,539,400.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	38,657,538.50	110,951,131.43
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	315,470,718.50	676,915,605.43
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	213,304,000.00	489,831,625.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	213,304,000.00	489,831,625.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	528,774,718.50	1,166,747,230.43
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (өмнөх оны)	(190,313,116.16)	(594,853,762.20)
2.3.10	Хуримтлагдсан ашиг (тайлант оны)	(404,540,646.04)	(601,900,855.76)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(494,853,762.20)	(1,096,754,617.96)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>33,920,956.30</u>	<u>69,992,612.47</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)		
4	Хүүгийн орлого	1,097,590.98	
5	Ерөнхий ба удирдлагын зардал	365,574,459.42	529,570,382.83
6	Санхүүгийн зардал	38,657,538.50	72,293,592.93
7	Бусад зардал	1,296,480.00	36,880.00
8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(404,430,886.94)	(601,900,855.76)
9	Орлогын татварын зардал	109,759.10	
10	Татварын дараах ашиг (алдагдал)	(404,540,646.04)	(601,900,855.76)
11	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(404,540,646.04)	(601,900,855.76)
13	Бусад дэлгэрэнгүй орлого		
14	Орлогын нийт дүн	(404,540,646.04)	(601,900,855.76)
15	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/ Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	(190,313,116.19)	(90,313,116.19)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
3	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	(190,313,116.19)	(90,313,116.19)
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)		(404,540,646.04)	
5	Бусад дэлгэрэнгүй орлого			
6	Өмчид гарсан өөрчлөлт			
7	Зарласан ногдол ашиг			
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
9	2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	100,000,000.00	(594,853,762.20)	(494,853,762.20)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
11	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	(594,853,762.20)	(494,853,762.20)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(601,900,855.76)	(601,900,855.76)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			
14	Өмчид гарсан өөрчлөлт			
15	Зарласан ногдол ашиг			
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
17	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	100,000,000.00	(1,196,754,617.96)	(1,096,754,617.96)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	446,481.00
	Бусад мөнгөн орлого	0	446,481.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	381,056,764.11	-521,401,341.94
	Ажиллагчдад төлсөн	224,542,683.62	355,707,097.16
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	66,782,911.99	105,144,102.80
	Бараа материал худалдан авахад төлсөн	414,000.00	2,640,077.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,200,000.00	4,254,637.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	9,242,967.59	0
	Татварын байгууллагад төлсөн	23,916,418.41	37,612,858.39
	Даатгалын төлбөрт төлсөн	300,000.00	0
	Бусад мөнгөн зарлага	53,657,782.17	16,042,569.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>-381,056,764.11</u>	<u>-520,954,860.94</u>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,755,018.98	0
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	20,657,428.00	
	Хүлээн авсан хүүгийн орлого	1,097,590.98	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,332,900.00	21,158,441.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,332,900.00	21,158,441.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>10,422,118.98</u>	<u>-21,158,441.00</u>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	276,527,625.00	560,539,400.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	276,527,625.00	560,539,400.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>276,527,625.00</u>	<u>560,539,400.00</u>
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-94,107,020.13	18,426,098.06
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	117,036,663.16	22,929,643.03
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,929,643.03	41,355,741.09

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	Мян. төг	-	129,536.8	-	(129,536.8)	-
	Бусад орлого	Мян. төг	-	501,776.6	-	(501,776.6)	-
2	Үйл ажиллагааны зардал	Мян. төг	405,638.2	1,080,802.5	601,900.8	(478,901.7)	55.6
1	Цалингийн зардал	Мян. төг	280,523.0	636,672.0	440,380.8	(196,291.2)	69.2
2	ЭМНД Шимтгэл	Мян. төг	35,445.7	85,950.7	57,149.5	(28,801.2)	67.0
7	Сургалтын зардал	Мян. төг	6,652.2	40,066.0	288.5	(39,777.5)	0.7
8	Томилолт / гадаад, дотоод/	Мян. төг	440.0	20,000.0	0.0	(20,000.0)	-
10	Гэрээт ажлын хөлс	Мян. төг	13,915.0	58,568.7	7,900.0	(0,968.7)	13.7
11	Бичиг хэрэг	Мян. төг	444.9	8,000.0	2,411.0	(5,589.0)	30.1
12	Шатахуун, шатах тослох материал	Мян. төг	2,200.0	6,000.0	3,756.9	(2,243.1)	62.6
13	Түрээс	Мян. төг	-	114,900.0	-	(114,900.0)	-
14	Хэвлэл захиалга, шуудан харилцаа холбоо	Мян. төг	370.8	8,000.0	1,273.5	(6,726.5)	15.9
15	Хангамжийн материал	Мян. төг	777.6	17,000.0	189.8	(16,810.2)	-
16	Мэдээлэл, зар сурталчилгаа	Мян. төг	5,000.0	8,000.0	5,224.0	(2,776.0)	65.3
17	Хурал зөвлөгөөн, уулзалт	Мян. төг	13,188.8	27,000.0	699.8	26,300.2	2.6
18	Даатгалын зардал	Мян. төг	150.0		150.0	150.0	-
19	Нийгмийн арга хэмжээ	Мян. төг	1,440.1	15,000.0	1,921.6	(13,078.4)	12.8
20	Бусад	Мян. төг	1,296.5		36.9	36.9	-
21	Татвар хураамж	Мян. төг	109.7	5,000.0		(5,000.0)	-
22	Хүүгийн зардал	Мян. төг	38,657.5		72,293.6	72,293.6	-
23	Элэгдлийн зардал	Мян. төг	5,026.3		8,711.7	8,711.7	-
3	Хөрөнгө оруулалтын зардал	Мян. төг	11,332.9	115,000.0	24,225.8	(90,774.2)	21.1
1	Тавилга, эд хогшил	Мян. төг	-	80,000.0		(80,000.0)	-
2	Компьютер, дагалдах хэрэгсэл	Мян. төг	11,332.9	30,000.0	24,225.8	(5,774.2)	80.7
3	Биет бус хөрөнгө	Мян. төг	-	5,000.0		(5,000.0)	-
	Нийт зардал	Мян. төг	416,971.1	1,195,802.5	626,126.6	(569,675.9)	52.4
	НИЙТ АШИГ	Мян. төг	(416,971.1)	(564,489.1)	(626,126.6)		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Уваа уул аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Уваа уул аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Эрдэнэс монгол” ХХК болон охин компаниудын хэмжээнд дагаж мөрддөг байна

2021 онд ТУЗ-өөс дотоод аудиторын 3 орон тоо баталсан байна. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын нэгж нь 2021 онд үйл ажиллагааны 9, сургалтын 12, дотоод аудитын чиглэлээр 7 ажил /Компанийн эрсдэлийн удирдлагын үр нөлөөтэй байдал, Компанийн төсөв хөрөнгө, нөөцийн ашиглалт, зарцуулалт нь хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байгаа эсэх, Компанийн дотоод хяналтын тогтолцооны үнэлгээ, Компанийн засаглалын үйл явцыг үнэлэх зэрэг/ хийхээр төлөвлөж, төлөвлөсөн ажлаа бүрэн гүйцэтгэсэн байна. Дотоод хяналт, Засаглал, Эрсдэлийн удирдлагыг “сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт хийж, нийт 15 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэнгүй тайлангийн нийт зардлын 403.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, 2021 оны Орлогын дэлгэнгүй тайлангийн нийт зардлын 601.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн зорилго нь хүний хөгжлийг дэмжсэн, хөрөнгө оруулагч, харилцагчдын итгэлийг хүлээсэн, мэдлэг технологид суурилсан хөгжлийг дэмжих зорилготой. Монгол Улсын хөгжлийн бодлого чиглэлтэй уялдуулан, мэргэжлийн өндөр түвшинд хөрөнгийн зах зээлд хүртээмжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулагч нарын үнэ цэнийг нэмэгдүүлэх, урт хугацааны хамтын ажиллагаа түншлэлийг бий болгох, байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжсэн, эрсдэл өгөөжийн зохистой харьцаа бүхий төслүүдийг санал болгох, олон улсад өрсөлдөхүйц, өндөр ёс зүйтэй, чадварлаг, мэргэшсэн баг хамт олон болох, инновац, мэдээлэл технологийн дэвшлийг ашиглан хөрөнгө оруулалтын дэд бүтцийг боловсронгуй болгож хөнгөвчлөх зорилттойгоор хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бизнесийн зөвлөгөө үзүүлэх,
- Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа,
- эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ҮЦК ХХК статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрдэнэс Ассет Менежмент ҮЦК ХХК нь Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 02 дугаар сарын 02-ны 06 тоот тогтоолоор 100.0 сая төгрөгийн дүрмийн сантай, Эрдэнэс Монгол ХХК-ийн 100.0 хувийн хөрөнгө оруулалттай охин компани хэлбэртэй байгуулагдсан. “Эрдэнэс Монгол” нэгдлийн хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг болох, хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа явуулах өөрийн охин компани хэлбэрээр хөгжүүлэх шийдвэр гаргасны үндсэн дээр үйл ажиллагаагаа идэвхжүүлж, Санхүүгийн зохицуулах хорооноос Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 2020 онд авсан байна.

Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 32.0 сая төгрөгөөр /дарга сарын 715.0 мянга, гишүүд 650.0 мянган төгрөг/ тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн Удирдах Зөвлөл, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитын нэгжтэй бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлуудыг

төлөвлөгөөний дагуу болон шаардлагатай үед зарлан хуралдуулж, холбогдох асуудлуудыг шийдвэрлэдэг байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон Дотоод аудитын журамтай. Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг батлан ажиллаж, үр дүнг тооцон хэлэлцэж, холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаж ирсэн байна.

- 2021 оны шинэ бүтцээр Эрсдэлийн удирдлагын газартай болж, “Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр” боловсруулан, ТУЗ-ийн тогтоолоор баталсан байна.

ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны 03 тогтоолоор 2021 оны бизнес төлөвлөгөөнд компанийн зохион байгуулалтын бүтцийг оруулан баталж, орон тоог 19 /ТУЗ, дотоод аудитыг оруулахгүйгээр/, 2021 оны 07 дугаар сарын 08-ны 09 дүгээр тогтоолоор бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн 20 /ТУЗ, дотоод аудитыг оруулахгүйгээр/ тогтоосон нь 2020 оны 01 дүгээр тогтоолоор 13 орон тоо баталж байснаас 6-7 орон тоогоор, цалингийн санг 89.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 636.7 сая төгрөгөөр тогтоожээ.

Цалингийн сан 440.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь төлөвлөгөөнөөс 196.3 сая төгрөгөөр дутуу, өмнөх оноос 159.9 сая төгрөгөөр илүү байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.2. “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх...” ;” заалттай нийцээгүй байна.

2021 оны 1 дүгээр сарын 20-ноос томилогдсон гүйцэтгэх захирлын цалинг өмнөх гүйцэтгэх захирлын цалингаас 0.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 5.0 сая төгрөгөөр тогтоож, жолоочийн цалин, шатахуун, автомашины засвар үйлчилгээнд /хэдийгээр компани өөрийн автомашингүй боловч/ тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд 1.2 сая жолоочийн цалинд 14.4 сая төгрөгийн зардал гаргасан нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл. “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх: 76.1.9.компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;”, захирлын контрактын 6.4-д "автомашинаар хангах, түүнтэй холбоотой зардлыг байгууллага бүрэн хариуцна" гэсэн заалт болон ТУЗ-өөс 2021 онд жолоочийн орон тоог шинээр баталж өгсний дагуу эдгээр зардал гарсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2021 оны А/07 тушаалаар “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, А/17 тушаалаар нэмэлт оруулсан байна.
- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,929.6	41,355.7	18,426.1
Авлага	269.1	2,050.4	1,781.3
Урьдчилгаа	150.0	500.2	350.2
Үндсэн хөрөнгө	10,572.2	26,086.3	15,514.1
Нийт хөрөнгийн дүн	33,920.9	69,992.6	36,071.7

Өр төлбөрийн дүн	528,774.7	1,166,747.2	637,972.5
Богино хугацаат өглөг	315,470.7	676,915.6	361,444.9
Урт хугацаат өглөг	213,304.0	489,831.6	276,527.6
Эздийн өмч	(494,853.8)	(1,096,754.6)	(601,900.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	33,920.9	69,992.6	36,071.7

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах данстуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Тайлан оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 41.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 18.4 сая төгрөгөөр өссөн байна. Үлдэгдэлд касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.3 сая, Хас банк дахь харилцах дансанд байгаа 41.0 сая төгрөг байна.
- Тайлант онд авлагын үлдэгдэл 1.8 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалтын хүрээнд үүссэн бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага 1.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 24.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авснаар
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 676.9 сая, урт хугацаат өр төлбөр дансанд 489.8 сая төгрөгийн өр төлбөр байгаа нь өөрийн толгой компани Эрдэнэс монгол ХХК-аас авсан үйл ажиллагааны санхүүжилтийн зээл байна. Тайлант хугацаанд зээл төлөгдөөгүй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлыг аккрузал суурьт үндэслэн бүртгэхээр тусгасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу Ерөнхий ба удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардал гэж ангилан бүртгэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад цалингийн зардал 159.9 сая, НДШ-ийн зардал 21.7 сая, бичиг хэргийн зардал 2.0 сая, шатахууны зардал 1.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон тоо зарим ажилтны цалин нэмэгдсэнээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт орлогыг 531.3 сая төгрөгөөр, зардлыг 1,195.8 сая төгрөгөөр 564.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна. Алдагдлыг “Эрдэнэс монгол” ХХК-аас авах 564.5 сая төгрөгийн зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орлого бүрдүүлээгүй, 560.5 сая төгрөгийн зээлийн санхүүжилт авч, 601.9 сая төгрөгийн зардал гарган, 601.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагаа эхлээгүйгээс орлогын төлөвлөгөө тасарсан, нийт зардлын гүйцэтгэл 601.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 594.1 сая төгрөг буюу 49.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авахад зээлийн эх үүсвэрээс 24.2 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэс ассет менежментийн 2021 онд нийт 467.0 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 132.0 сая төгрөгийн 131 мэдээллийг хугацаандаа, 335.0 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 30.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 4.4 сая төгрөгийг залруулж, 25.8 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 20.1 сая төгрөгийн зөрчилд өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орлого бүрдүүлэлт, бүтэц, орон тооны асуудалд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11.9 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс, 6.9 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 5.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 5.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 6.0 сая төгрөгийн түвшнээс 1.0 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 6.9 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг санхүүгийн байдлын тайланд 0.1 сая төгрөгөөр дутуу тусгагдсан;
- Журналын бичилтээр бараа материалын 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан боловч санхүүгийн тайланд Урьдчилж төлсөн зардлын үлдэгдлээр тайлагнасан;
- Шатахууныг бараа материалын дансаар дамжуулалгүй 0.7 сая төгрөгийг зардалд шууд бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн тайлан болон тодруулгад худалдан авсан дүнг 5.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг тус тус залруулав.

8.2 Албан шаардлага

Өнгөрсөн онд 5.0 сая төгрөгөөр Веб сайт хийлгэсэн нь чанарын шаардлага хангахгүйгээс 2021 оны төсөвт тусгагдсаны дагуу дахин 5.0 сая төгрөгөөр шинээр хийлгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.”санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 6 дугаар зүйлийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.Зардалтай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Гүйцэтгэх захирлын 2019 оны А/006 тушаалаар хоол, унааны хөнгөлөлтийг тус тусад нь салгаагүй, нэгтгэн өдрийн 6.5 мянган төгрөгөөр баталсан учир захиралд унааны хөнгөлөлт тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.”санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 6 дугаар зүйлийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.Өгсөн зөвлөмж:

Унаа, хоолны хөнгөлөлтийг салгаж батлуулах, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгохгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн
аудитын тайлан**

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/69/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл санхүүгийн байдлын тайланд дутуу тусгагдсан.	Залруулга хийх	1	160.8	1	160.8								
2	Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/69/НА-СТА-ТӨА	Журналын бичилтээр бараа материалын үлдэгдэлтэй гарсан боловч санхүүгийн тайланд Урьдчилж төлсөн зардлын үлдэгдлээр тайлагнасан	Залруулга хийх	1	500.2	1	500.2								
3	Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/69/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн тайлан болон тодруулгад худалдан авсан дүнг 5,589.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	Залруулга хийх	1	5,589.7	1	5,589.7								
4	Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/69/НА-СТА-ТӨА	Шатахууныг бараа материалын дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн	Залруулга хийх	1	689.3	1	689.3								
5	Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/69/НА-СТА-ТӨА	Өнгөрсөн онд 5.0 сая төгрөгөөр Веб сайт хийлгэсэн нь чанарын шаардлага хангахгүйгээс 2021 оны төсөвт тусгагдсаны дагуу дахин 5.0 сая төгрөгөөр шинээр хийлгэсэн байна.	Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах	1	5,000.0					1	5,000.0				
8	Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/69/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын 2019 оны А/006 тушаалаар хоол, унааны хөнгөлөлтийг тус тусад нь салгаагүй, нэгтгэн өдрийн 6.5 мянган төгрөгөөр баталсан учир захиралд унааны хөнгөлөлт бодогдож байна.	Унааны хөнгөлөлтийг давхардуулан олгохгүй байх	1	-								1	-	
ДҮН					6	11,940.0	4	6,940.0			1	5,000.0			1	-
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/69/НА-СТА-ТӨА	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 334,984.5 мянган төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх	1	334,984.5					1	334,984.5				
ДҮН					1	334,984.5					1	334,984.5				
НИЙТ ДҮН					7	346,924.5	4	6,940.0			2	339,984.5			1	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 555/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/69/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өнгөрсөн онд 5,000,000.00 төгрөгөөр Веб сайт хийлгэсэн нь чанарын шаардлага хангахгүйгээс 2021 оны төсөвт тусгаж дахин 5,000,000.00 төгрөгөөр шинээр хийлгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ны захирал Д.Болормаа, нягтлан бодогч Г.Ганцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 556/А.0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/69/НА-СТА-ТӨА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангах албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, тайлант онд зөрчлийг давтан гаргаж, байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулбал зохих 149 мэдээллээс 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4 “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3. “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Эрдэнэс ассет менежмент ҮЦК ХХК-ны захирал Д.Болормаад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ч.МӨНХТУЯА

